



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" 318 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, уур амьсгалын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн, нийт 1,347,500.00 (нэг сая гурван зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгаль орчин, уур амьсгалын сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албаны дарга М.Батсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004637
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн
9 дугаар тогтоолын хавсралт

Байгаль орчин, уур амьсгалын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн
цагдаагийн албанд балансаас балансад шилжэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ(төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэх өртөг(төгрөг)
1	Хүнд даацын жин	12/31/2022	1	ш	753,500	-	753,500
2	Микро жин	12/31/2022	1	ш	594,000	-	594,000
	НИЙТ		2		1,347,500	-	1,347,500